



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ОРА-2022 /13/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Эрдэнэт хот 2022 он</p>	<p>Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Б.Эрдэнэ Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn</p> <p>Аудитор: Т.Болормаа Утас: 70350757 Цахим хаяг: bolormaat@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **Агуулга**

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3. Аудитын тайлан .....	12
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	13
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
4. Аудитын илрүүлэлт.....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.2 Албан шаардлага .....	17
4.3 Зөвлөмж .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	19

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан
ТУХ	Төслийн удирдах хороо



**ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Урт булаг баг, Ханддоржийн  
гудамж, Утас/Факс: 70359826  
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2022.02.25 № 15

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Аудитын санал дүгнэлт**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\my doc \alban bichig\ 2022-A4.doc

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,302,370,435.74</u></b>	<b><u>7,430,448,607.16</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	856,134.51
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	856,134.51
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	856,134.51
31211	Төрийн сангийн харилцах		856,134.51
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	69,287,272.02	5,756,297,735.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	45,380,343.02	
33300	Татаас, санхүүжилтийн авлага	23,906,929.00	5,756,297,735.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,233,083,163.72	1,673,294,737.65
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	1,206,339,290.43	1,335,033,209.69
35110	Тусгай зориулалттай материал	912,945,934.12	1,010,365,576.39
35130	Эм боох материал	293,393,356.31	324,667,633.30
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	26,743,873.29	338,261,527.96
35410	Бичиг хэргийн материал	3,351,800.00	420,000.00
35420	Аж ахуйн материал		1,658,910.00
35440	Түлш, шатах тослох материал	10,554,414.29	2,750,603.96
35450	Барилгын засварын материал	3,994,300.00	326,232,104.00
35460	Хүнсний материал	287,109.00	1,519,910.00
35470	Бусад хангамжийн материал	8,556,250.00	5,680,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>30,259,065,102.99</u></b>	<b><u>34,200,888,028.82</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	30,259,065,102.99	34,200,888,028.82
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	27,395,345,102.99	31,337,168,028.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	25,083,579,303.53	25,691,263,278.03
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,708,650,852.99	2,802,980,241.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	628,274,338.00	628,274,338.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	463,174,431.12	518,563,993.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,239,874,836.81	15,218,860,323.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	5,644,059,571.03	7,079,955,199.22
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	387,456,049.83	393,876,034.83
39208	Хуримтлагдсан элэгдэл	255,634,288.87	284,514,644.28
39214	Бусад үндсэн хөрөнгө	210,091,146.00	210,091,146.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	82,411,427.17	119,183,012.72
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,863,720,000.00	2,863,720,000.00
39301	Програм хангамж	9,883,087.00	9,883,087.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	9,883,087.00	9,883,087.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,863,720,000.00	2,863,720,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>31,561,435,538.73</u></b>	<b><u>41,631,336,635.98</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>92,929.00</u></b>	<b><u>442,990,700.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	92,929.00	442,990,700.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	92,929.00	442,990,700.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	92,929.00	
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг		442,990,700.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>31,561,342,609.73</u></b>	<b><u>41,188,345,935.98</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	31,561,342,609.73	41,188,345,935.98
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	10,297,152,047.96	10,297,152,047.96
51101	Өмч: - төрийн	10,297,152,047.96	10,297,152,047.96
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,362,346,005.31	10,989,349,331.56
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,126,836,103.37)	1,316,965,662.29
51220	Тайлант үеийн үр дүн	4,489,182,108.68	9,672,383,669.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	19,901,844,556.46	19,901,844,556.46
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>31,561,435,538.73</u></b>	<b><u>41,631,336,635.98</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	19,963,024,602.16	32,172,547,139.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,230,457,090.16	9,166,335,065.71
120	Нийтлэг татварын бус орлого	481,378,578.91	2,288,353,209.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	481,378,578.91	2,288,353,209.97
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,438,348.27	649,387,897.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,896,657.73	11,065,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	224,043,572.91	1,627,900,312.97
122	Тусламжийн орлого	5,749,078,511.25	6,877,981,855.74
122001	Хандив тусламж /дотоод/		6,764,234,922.01
122002	Хандив тусламж /гадаад/	5,749,078,511.25	113,746,933.73
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,732,567,512.00	23,006,212,074.26
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,867,907,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,867,907,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	801,303,531.00	1,179,736,678.26
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	32,667,857.00	
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	366,200,000.00	445,199,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	402,435,674.00	720,625,828.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		13,911,850.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	5,063,356,381.00	21,826,475,396.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	5,063,356,381.00	21,826,475,396.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,473,842,493.48	22,500,163,470.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	15,473,842,493.48	22,500,163,470.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,401,239,499.60	21,777,697,170.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8,544,085,579.20	9,864,214,973.37
210101	Үндсэн цалин	4,169,055,998.86	4,450,233,287.16
210102	Нэмэгдэл	3,678,759,402.73	4,267,627,322.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	319,520,639.59	362,547,100.00
210104	Урамшуулал	376,749,538.02	783,807,263.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,055,618,803.00	1,292,540,796.58
210201	Тэтгэврийн даатгал	758,287,808.00	934,826,930.59
210202	Тэтгэмжийн даатгал	63,419,326.00	89,408,390.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	64,518,655.00	71,686,208.69
210204	Ажилгүйдлийн даатгал	25,454,026.00	18,418,718.91
210205	Эрүүл мэндийн даатгал	143,938,988.00	178,200,547.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	503,487,792.96	584,131,454.15
210301	Гэрэл, цахилгаан	200,326,978.58	223,024,233.27
210302	Түлш, халаалт	146,446,148.46	151,117,292.88
210303	Цэвэр, бохир ус	156,714,665.92	209,989,928.00

Бүсийн оношилгоо эмчилгээний 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	238,040,553.71	292,005,117.53
210401	Бичиг хэрэг	13,577,210.00	25,241,782.00
210402	Тээвэр, шатахуун	93,361,185.61	102,274,602.69
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,593,199.04	2,414,650.84
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	27,174,689.00	44,311,844.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,932,406.00	80,249,200.00
210408	Бараа материал акалсны зардал	49,401,864.06	37,513,038.00
2105	Нормативт зардал	2,771,825,225.43	6,559,233,469.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,416,118,254.43	6,170,392,120.32
210502	Хоол, хүнс	339,635,330.00	368,741,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,071,641.00	20,099,749.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	85,032,308.00	115,274,174.00
210604	Урсгал засвар	85,032,308.00	115,274,174.00
2107	Томилолт, зочны зардал	6,949,070.00	4,120,035.00
210702	Дотоод албан томилолт	6,949,070.00	4,120,035.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	123,628,766.50	116,591,420.84
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,850,954.00	47,138,425.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,280,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	4,246,545.00	4,906,622.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825,192.50	863,220.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	528,000.00	319,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,906,075.00	8,113,929.84
210807	Газрын төлбөр	36,995,800.00	21,717,900.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38,996,200.00	33,532,324.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,072,571,400.80	2,949,585,729.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	480,000.00	5,676,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,072,091,400.80	2,943,909,729.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	72,602,993.88	722,466,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,157,288.00	722,466,300.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,157,288.00	722,466,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	27,445,705.88	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,445,705.88	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>4,489,182,108.68</u>	<u>9,672,383,669.27</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,489,182,108.68</u>	<u>9,672,383,669.27</u>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	10,297,152,047.96	19,901,844,556.46	1,362,346,005.31	31,561,342,609.73
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>10,297,152,047.96</b>	<b>19,901,844,556.46</b>	<b>1,362,346,005.31</b>	31,561,342,609.73
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,297,152,047.96</b>	<b>19,901,844,556.46</b>	<b>1,362,346,005.31</b>	31,561,342,609.73
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,297,152,047.96</b>	<b>19,901,844,556.46</b>	<b>1,362,346,005.31</b>	31,561,342,609.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-45,380,343.02	-45,380,343.02
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>10,297,152,047.96</b>	<b>19,901,844,556.46</b>	<b>1,316,965,662.29</b>	31,515,962,266.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			9,672,383,669.27	9,672,383,669.27
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>10,297,152,047.96</b>	<b>19,901,844,556.46</b>	<b>10,989,349,331.56</b>	41,188,345,935.98

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>13,989,995,447.00</b>	<b>17,934,181,236.26</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>257,427,935.00</b>	<b>660,452,897.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	257,427,935.00	660,452,897.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	257,335,006.00	660,452,897.00
1E+06	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	191,438,348.27	<b>649,387,897.00</b>
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	65,896,657.73	11,065,000.00
120009	Бусад орлого	92,929.00	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>13,732,567,512.00</b>	<b>17,273,728,339.26</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	7,867,907,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,867,907,600.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	769,085,674.00	1,179,736,678.26
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	366,200,000.00	445,199,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	402,435,674.00	720,625,828.26
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	450,000.00	13,911,850.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	32,217,857.00	-
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	32,217,857.00	
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,063,356,381.00	16,093,991,661.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,063,356,381.00	16,093,991,661.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>13,685,880,001.00</b>	<b>17,925,574,301.75</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>13,685,880,001.00</b>	<b>17,925,574,301.75</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>13,613,184,078.12</b>	<b>17,213,216,701.75</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	8,589,465,922.22	9,864,214,973.37
210101	Үндсэн цалин	4,678,781,451.20	4,450,233,287.16
210102	Нэмэгдэл	2,940,809,723.64	4,267,627,322.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	388,508,835.88	362,547,100.00
210104	Урамшуулал	581,365,911.50	783,807,263.49
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,055,618,803.00	1,292,540,796.58
210201	Тэтгэврийн даатгал	765,364,303.00	934,826,930.59
210202	Тэтгэмжийн даатгал	72,563,700.00	89,408,390.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	58,050,800.00	71,686,208.69
210204	Ажилгүйдлийн даатгал	14,512,900.00	18,418,718.91
210205	Эрүүл мэндийн даатгал	145,127,100.00	178,200,547.64
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	503,487,792.96	-
210301	Гэрэл, цахилгаан	200,326,978.58	
210302	Түлш, халаалт	146,446,148.46	
210303	Цэвэр, бохир ус	156,714,665.92	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	201,273,305.04	27,499,841.36
210401	Бичиг хэрэг	16,056,000.00	
210402	Тээвэр, шатахуун	99,201,600.00	27,499,841.36
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,622,699.04	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,460,600.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	50,932,406.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	2,978,153,910.40	69,741,850.00

Бүсийн оношилгоо эмчилгээний 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,581,872,231.40	69,741,850.00
210502	Хоол, хүнс	339,842,439.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	56,439,240.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>153,519,008.00</b>	<b>26,509,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	51,618,400.00	6,800,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	
210604	Урсгал засвар	101,600,608.00	19,709,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>6,949,070.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	6,949,070.00	
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>124,092,266.50</b>	<b>-</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,314,454.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,280,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	4,246,545.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	825,192.50	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	528,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,906,075.00	
210807	Газрын төлбөр	36,995,800.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	38,996,200.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>624,000.00</b>	<b>5,932,710,240.44</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		5,927,490,240.44
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	624,000.00	5,220,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>72,695,922.88</b>	<b>712,357,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>45,157,288.00</b>	<b>712,357,600.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	45,157,288.00	712,357,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>27,538,634.88</b>	<b>-</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	27,538,634.88	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>304,115,446.00</b>	<b>8,606,934.51</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>304,115,446.00</b>	<b>7,750,800.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>304,115,446.00</b>	<b>7,750,800.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>304,115,446.00</b>	<b>7,750,800.00</b>
222001	Тоног төхөөрөмж		7,750,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	304,115,446.00	
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(304,115,446.00)</b>	<b>(7,750,800.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>=</b>	<b>=</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>856,134.51</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>-</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	17,337,225,745.00	16,754,444,558.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	17,337,225,745.00	16,754,444,558.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	17,337,225,745.00	16,754,444,558.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	9,586,958,200.00	9,567,357,324.59
210101	Үндсэн цалин	4,391,268,100.00	4,261,476,505.94
210102	Нэмэгдэл	4,187,034,700.00	4,187,034,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	349,965,000.00	349,965,000.00
210104	Урамшуулал	658,690,400.00	768,881,118.65
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	1,433,847,645.00	1,254,026,992.97
210201	Тэтгэврийн даатгал	1,089,711,765.00	909,891,112.97
210202	Тэтгэмжийн даатгал	86,033,970.00	86,033,970.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	68,827,216.00	68,827,216.00
210204	Ажилгүйдлийн даатгал	17,206,754.00	17,206,754.00
210205	Эрүүл мэндийн даатгал	172,067,940.00	172,067,940.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	6,316,419,900.00	5,933,060,240.44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,316,419,900.00	5,933,060,240.44
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	17,037,225,745.00	16,754,444,558.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	16,397,213,945.00	16,093,991,661.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	16,397,213,945.00	16,093,991,661.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	640,011,800.00	660,452,897.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	628,946,800.00	649,387,897.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,065,000.00	11,065,000.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		856,134.51
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	505.00	505.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	404.00	404.00
620003	Үйлчлэх ажилтан	100.00	100.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 20-ны хооронд Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Болормаа нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 54 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дэвшилтэт технологи нэвтрүүлсэн оношилгоо эмчилгээ, сувилахуйн цогц төв болох эрхэм зорилгын хүрээнд ажлын таатай нөхцөл, дэмжлэгт удирдлага, чадварлаг боловсон хүчний багаар сэтгэлд нийцсэн тусламж үзүүлнэ гэсэн зорилго дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр өөрчлөлт орсон.
- Төсвийн тухай хууль 2021 оны 12 дугаар сарын 24-ны өдөр өөрчлөлт орсон.
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 3-р тогтоол

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсвийн 16,754,444.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 167,544.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75%-иар 125,658.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,069,901.1 мянган төгрөгөөр буюу 31.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	856.1	-856.1
Авлага	69,287.3	5,756,297.7	5,687,010.4
Бараа материал	1,233,083.2	1,673,294.7	440,211.5
Үндсэн хөрөнгө	30,259,065.1	34,200,888.0	3,941,822.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>31,561,435.6</b>	<b>41,631,336.6</b>	<b>10,069,901.0</b>
Өр төлбөр	92.9	442,990.7	442,897.8
Хуримтлагдсан үр дүн	1,362,346.0	1,316,965.7	-45,380.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>31,561,435.6</b>	<b>41,631,336.6</b>	<b>10,069,901.0</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 5,732,483.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой авлагын үлдэгдэл 5,756,297.7 мянган төгрөг болж өссөн.
- Бараа материалын дансанд 1,627,900.3 мянган төгрөгийн бараа материал хандив тусламж, үнэ төлбөргүй ирснээс хамаарч бараа материалын дүн нэмэгдсэн.
- Үндсэн хөрөнгөд хандиваар 6,877,981.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж, 292,643.2 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан.

- Өр төлбөрийн дүн 442,990.7 мянган төгрөг нь эмийн өр бөгөөд оны эцэст тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь эрүүл мэндийн даатгалын сангаас 5,500,000.0 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос санхүүжих 287,768.0 мянга, улсын төсвөөс санхүүжих 9,748,713.0 мянган төгрөг нийт 15,567,481.0 мянган төгрөгөөр тооцож төсвийн санал хүргүүлсэн байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,632,473.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, эрүүл мэндийн даатгалын сангаас 5,500,932.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 339,765.0 мянган төгрөг нийт 13,473,171.2 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 16,397,213.9 мянган төгрөг, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 640,011.8 мянган төгрөг нийт 17,394,456.4 мянган төгрөгийн санхүүжилтийн эрх нээгдэж, урсгал зардалд 16,754,444.6 мянган төгрөг зарцуулсан.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,754,444.6 мянган төгрөг буюу 96.64 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 19,600.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл 179,820.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 383,359.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулснаас шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар Эрүүл мэндийн хөгжлийн газраас 26,751.8 мянга, Эрүүл мэндийн яамнаас 1,495.0 мянга, Эрүүл мэндийн даатгалын газраас 240.0 мянга, аймгийн Засаг даргаас 410,300.0 мянга, эрүүл мэндийн газраас 712,414.0 мянга, Онцгой байдлын газраас 2,190.0 мянга, Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 8,709.0 мянга, бусад эх үүсвэрээс 17,636.9 мянга нийт 1,179,736.7 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 296,857.6 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх 38,513.8 мянга, хангамж, бараа материалд 27,499.8 мянга, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд 69,741.8 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 26,509.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 7,400.8 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 712,357.6 мянга, нийт 1,178,880.5 мянган төгрөг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлээгүй, санхүүгийн тайлан бүтэн жилээр мэдээлэх ёстойг хугацаанд нь мэдээлээгүй, тендерт оролцогчийн мэдээллийг буруу, дутуу мэдээлсэн, 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээнээс 83.2 сая төгрөгийн 5 гүйлгээ, зарлагын гүйлгээнээс 263.3 сая төгрөгийн 17 гүйлгээ мэдээлээгүй орхигдуулсан байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн боловч зарим мэдээлэл дутуу, буруу оруулсан, харин Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1-т “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид” гэж заасны дагуу үнэлээгүй, аймгийн засаг даргын А/692, Эрүүл мэндийн газрын даргын А/135 тушаал нь шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 27,431.8 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 660.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 45,287.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт-4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	660.0	1	660.0	-		
Албан шаардлага	2	27,431.8	2	27,431.8	-	-	-
Зөвлөмж	2	45,287.4	2	45,287.4	-		-
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>73,379.2</b>	<b>5</b>	<b>73,379.2</b>			-

### 3.11 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 6,522,963.4 мянган төгрөгийн 7 алдаа зөрчил илэрснээс 2,348.7 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 431,947.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 6,088,667.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 7 алдаа, зөрчлийн дүн 6,522,963.4 мянган төгрөг ба үүнээс 6,435,122.6 төгрөгийн 3 алдаа зөрчлийг материаллаг бус гэж үзсэн, харин үлдсэн 4 алдаа зөрчлийн 87,840.8 мянган төгрөгийг материаллаг зөрчил гэж үзсэн.

Тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 167,544.4 мянган төгрөгөөс материаллаг алдаа зөрчлийн дүн хэтрээгүй тул Зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

**4.1 Залруулсан алдаа:** Аудитаар хийгдсэн залруулга байхгүй болно.

#### 4.2 Төлбөрийн акт:

- Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн Ц.Наран-Эрдэнэд 2021 оны дөрөвдүгээр улирлын үр дүнгийн урамшуулал, ээлжийн амралт биеэр эдэлж чадаагүй тул хуульд заасан мөнгөн урамшууллыг байгууллагынхаа төсөвт багтаан олгох тухай А/135 дугаар тушаалын дагуу үндсэн цалингийн 75%-иар тооцож 784.4 мянган төгрөгийг 2021 оны 12 сарын цалинд нэмж олгосон байна. Гэтэл Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал нь 12 сард ээлжийн амралтын нөхөн олговроо авсан, мөн улирал бүр үр дүнгийн урамшуулал авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 79.1-д “Ажилтанд жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд мөнгөн урамшуулал олгож болно. Мөнгөн урамшуулал олгох журмыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцсоны үндсэн дээр ажил олгогчийн шийдвэрээр зохицуулна”, Төрийн албаны тухай хуулийн 61.1.9-д “ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид түүний зөвшөөрснөөр 1.5 сарын албан тушаалын цалинтай тэнцэх мөнгөн урамшуулал олгох, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1-т “төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Ц.Наран-Эрдэнэд ээлжийн амралтын нөхөн олговор, үр дүнгийн урамшуулал хэлбэрээр олгосон 784.4 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

- Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн Б/05, 2021 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн Б/94 дүгээр тушаалаар сахилгын шийтгэл оногдуулсан 3 ажилтанд 2021 оны 2, 3-р улирлын үр дүнгийн урамшуулал 1,564.3 мянган төгрөгийг бодож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 41.2.2-д "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.7-д "хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн 3 ажилтанд илүү тооцож олгосон үр дүнгийн урамшуулал 1,564.3 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

#### 4.3 Албан шаардлага

- Тус байгууллагын тусгай зориулалтын бараа материалын дансанд сандал, ширээ, принтер зэрэг 53 нэр төрлийн 352 ширхэг 82,452.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай зүйлсийг бүртгэсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага дараах бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө", 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 4.4-д "Энэ хуулийн 4.1.3-т заасан стандартыг Төсвийн тухай хуулийн 4.1.34-т заасан байгууллага мөрдөнө", УСНББОУС 17-д үндсэн хөрөнгө гэдэг нь "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн шинж чанар агуулсан 82,452.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалын дансанд бүртгэлтэй байгаа материалыг нэр төрөл зориулалтаар нь ангилан 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулан бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

- Тус байгууллагын захирлыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар томилсон. Эрүүл мэндийн сайдтай үр дүнгийн гэрээ байгуулан ажилладаг байтал томилсон эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүй, Орхон аймгийн засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын даргын үр дүнгийн гэрээ үнэлж, дүгнэсэн хүснэгтийг тулгуурлан 2,000.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг захирал Ц.Наран-эрдэнэд олгосон байна. Мөн аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/692 дугаар захирамжаар 2021 оны ажлын гүйцэтгэлийн үр дүнг амжилттай хэрэгжүүлэн идэвх санаачилгатай ажиллаж буй төсвийн шууд захирагч нарт 1 сарын албан тушаалын цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох тухай шийдвэрийн дагуу Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Ц.Наран-Эрдэнэд үндсэн 1 сарын цалинтай тэнцэх хэмжээний буюу 1,039.1 мянган төгрөгийг 12 сард үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 40.1-т "Төсвийн шууд захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагч нь харьяалагдах дээд шатныхаа төсвийн захирагчтай төсвийн жил эхлэхээс өмнө үр дүнгийн гэрээ байгуулна", 40.3-д "Үр дүнгийн гэрээний биелэлтийг харьяалагдах дээд шатны төсвийн захирагч нь хагас, бүтэн жилээр дүгнэнэ.", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан

“Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2-д “Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно.”, 1.2.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал нь ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг эрх бүхий албан тушаалтнаар үнэлүүлээгүй, түүний тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал авч байгаа зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэв.

- Шилэн дансны цахим хуудсанд санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлээгүй, санхүүгийн тайлан бүтэн жилээр мэдээлэх ёстойг хугацаанд нь мэдээлээгүй, тендерт оролцогчийн мэдээллийг буруу, дутуу мэдээлсэн, 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээнээс 83.2 сая төгрөгийн 5 гүйлгээ, зарлагын гүйлгээнээс 263.3 сая төгрөгийн 17 гүйлгээ мэдээлээгүй орхигдуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлийн 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.1.5-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, 6.4.3-д “тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан”, 6.4.5-д “ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасны дагуу цахим сайтад орхигдуулсан, буруу, дутуу мэдээлсэн зөрчлийг арилгах тухай албан шаардлага хүргүүлэв.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Балансын данстай холбоотой**

###### Илрүүлэлт:

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 5,732,483.7 мянган төгрөгөөр нэмэгдэж 5,756,297.7 мянган төгрөг болж өссөн. Өр төлбөрийн дансанд эмийн өглөг 442,990.7 мянган төгрөг үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заалттай нийцэхгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуульд заасны дагуу төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

##### **2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой**

###### Илрүүлэлт:

2021 онд үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 273,375.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 66,390.0 мянга, нийт 339,765.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Харин гүйцэтгэлээр үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 660,452.9 мянган төгрөг төвлөрч 320,687.9 мянган төгрөгөөр давж биелсэн байна. Энэ нь Төсвийн

тухай хуулийн 5.1.1-д “төсвийн тогтвортой байдлыг хангасан байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тогтвортой байдлыг хангаж төсвийн орлогыг өмнөх оны гүйцэтгэлтэй ялдуулан бодитой төлөвлөж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бүсийн оношилгоо эмчилгээний төв	7	6,522,963.5			2	2,348.7	3	431,947.2	2	6,088,667.6